



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/11

Мандалговь

Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-2.2, 2.3 дахь хэсэг, 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан хаагчдад 2024 оны 1, 2 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг үндэслэн хавсралтын дагуу үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосугай.

Хоёр. Албан хаагчдын 2024 оны 1, 2 дугаар улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг батлагдсан хувиар тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч (Э.Саранзаяа)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



С.ХУЛАН

482412039

Орон нутгийн өмчийн газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн
01 дугаар тушаалын хавсралт



УЛИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН МӨНГӨН УРАМШУУЛАЛ АВАХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ҮНЭЛГЭЭ

№	Нэрс	Албан тушаал	Үнэлгээ	Үр дүнгийн хувь
1	Н.Гэрэлмаа	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	(91.0) Маш сайн	91.0
2	Б.Үүрийнтуяа	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	(96.8) Маш сайн	96.8
3	Б.Номингэрэл	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	(95.8) Машз сайн	95.8
4	Э.Саранзаяа	Нягтлан бодогч	(96.7) Маш сайн	96.7